



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр тогтоол, "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн турбогенератор №1-4-ийн шинэчлэлийн төслийн 2 дугаар шат турбингенератор №1-ын шинэчлэлийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт болох 19,400,000.00 (арван есөн сая дөрвөн зуун мянга) хүртэл европийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулах эрх олгохыг "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.



ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА